МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 22

УВС АЙМАГТ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ ИХ БАЙНА



Увс аймагт 2020 онд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 37.5 хувийг, 2021 оны 2 сарын байдлаар үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 50 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Тодруулбал, өмнөх онд 89, энэ оны 2 сард дээрх төрлийн 16 гэмт хэрэгт тус аймгийн прокурорын газраас хяналт тавьжээ.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

✓ **Увс аймагт хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт их байна.**

2020 онд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 37.5%-ийг, 2021 оны 2 сарын байдлаар үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 50%-ийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

- 2020 онд үйлдэгдсэн 89 хэргийн 69 буюу 77.5%
- 2021 оны 2 сард үйлдэгдсэн 16 хэрэг бүгд Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг байна.







Дээрх гэмт хэрэгт холбогдогчдын ихэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, бүрэн бус болон бүрэн бус дунд боловсролтой 26-35 насны эрэгтэй хүмүүс байна.



Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэгт заасан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 7 төрлийн хэрэг багтдаг бөгөөд үйлдэгдсэн гэмт хэргийг зүйл, анги тус бүрээр нь авч үзвэл 2020 онд үйлдэгдсэн 89 хэргийн 69 буюу 77.5 хувь нь, 2021 оны 2 сард үйлдэгдсэн 16 хэрэг бүгд Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус аймгийн Улаангом, Тэс сумдад хамгийн их үйлдэгджээ. Тухайлбал, тус суманд өмнөх онд гарсан нийт хэргийн 42.6 хувь, энэ оны 2 сард гарсан нийт хэргийн 68.7 хувь нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах

1.Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол 450.000-1.350.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 240-720 ЦАГ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ, ЭСХҮЛ 1-3 САР ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

2.Энэ гэмт хэргийг энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол 450.000-2.700.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 240-720 ЦАГ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ, ЭСХҮЛ 1-6 САР ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

www.prokuror.mn

Дээрх гэмт хэрэгт холбогдогчдын ихэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, бүрэн бус болон бүрэн бус дунд боловсролтой 26-35 насны эрэгтэй хүмүүс байгаа ажээ.

Увс аймгийн прокурорын газар дээрх нөхцөл байдалд үндэслэн Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авахуулахаар Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд албан бичиг, гэмт хэргийн гаралт их байгаа Улаангом, Тэс сумдад прокурорын мэдэгдэл тус тус хүргүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2860